



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/346

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Алдарт эх" одонгоор шагнагдсан ээжүүдийн шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаанд 2,731,000 төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах 2,731,000 (хоёр сая долоон зуун гучин нэгэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

